

ЗХЖШ-ын даргын 2019 оны 10 дугаар сарын  
27-ны өдрийн 11 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт



## ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын гүйцэтгэх үүрэг, албаны онцлог тохирсон цэрэгжлийн спортын төрлүүд, тэдгээрийн цол, зэргийн нэгдсэн ангиллыг тогтоож, болзол биелүүлсэн тамирчин, шүүгчдэд цэрэгжлийн спортын цол, зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Зорилго нь: Зэвсэгт хүчний цэргийн биеийн тамирын хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжин, цэрэгжлийн болон нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, улмаар гадаадын цэрэг, армиудтай бие бялдар, ур чадвараар өрсөлдөх чадавхитай цэргийн алба хаагчдыг бэлтгэхэд оршино.

1.3. Үйл ажиллагаа нь: "Биеийн тамир, спортын тухай", "Монгол Улсын Батлан хамгаалах тухай", "Зэвсэгт хүчний тухай" Монгол Улсын хуулиуд, Монгол Улсын спортын цол олгох зөвлөлийн дүрэм болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

### Хоёр. Цэрэгжлийн спортын цол, зэргийн зөвлөлийн үйл ажиллагаа

2.1. Зэвсэгт хүчин нь цэрэгжлийн спортын цолыг тодорхойлох, спортын зэрэг олгох зөвлөлтэй байна.

2.2. Цэрэгжлийн спортын цол, зэргийн зөвлөл нь ЗХЖШ-ын даргаар батлагдсан Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын болон Зэвсэгт хүчний хэмжээнд зохион байгуулагдсан цэрэгжлийн спортын аварга шалгаруулах тэмцээнүүдийн төрөл, амжилт, чансаа, зэрэглэлийг үндэслэн цэрэгжлийн спортын төрөл, цол, зэргийн нэгдсэн ангиллыг тогтоож, спортын цолыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад уламжлах, цэрэгжлийн спортын зэргийг журмын дагуу олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.3. Тамирчинд олгох Цэрэгжлийн спортын цол нь дараах ангилал, дараалалтай байна. Үүнд:

2.3.1. Спортын мастер;

2.3.2. Спортын дэд мастер;

2.4. Тамирчинд олгох Цэрэгжлийн спортын зэрэг нь дараах ангилал, дараалалтай байна. Үүнд:

2.3.1. Нэгдүгээр зэрэг;

2.3.2. Хоёрдугаар зэрэг;

2.3.3. Гуравдугаар зэрэг;

2.5. Шүүгчид олгох спортын зэрэг нь дараах нэршилтэй байна.

2.9.1. Улсын шүүгч;

2.9.2. Цэрэгжлийн спортын шүүгч;

2.6. Цэрэгжлийн спортоор цол, зэрэг хүртсэн тамирчин, шүүгчдийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, судалгаа гаргах, олон нийтэд сурталчлах ажлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын алба хариуцна.

2.7. Гишүүд нь цэрэгжлийн спортын цол, зэрэг олгохтой холбогдолтой баримт бичиг боловсруулах, дээд шатны байгууллагад хүргүүлэх, санал оруулах болон журамд заасан эрх, үүргийг эдлэх ба гишүүдийн ажил үүргийн хуваарийг зөвлөлийн дарга батална.

## Дөрөв. Цэрэгжлийн спортын цол, зэрэг олгох

4.1. Цэрэгжлийн спортын цолыг Зэвсэгт хүчний цэрэгжлийн спортын цол, зэргийн зөвлөлийн тодорхойлолтыг үндэслэн “Монгол Улсын спортын цол, зэргийн нэгдсэн ангилал, цол, зэрэг олгох журам”-ын дагуу Монгол Улсын “Спортын цол олгох зөвлөл” олгоно.

4.2. Цэрэгжлийн спортын 1, 2, 3 дугаар зэргийг тамирчны үзүүлсэн амжилт, тэмцээний протокол, тодорхойлолтыг харгалзан “Цэрэгжлийн спортын цол, зэргийн нэгдсэн ангилал, цол, зэрэг олгох журмын” дагуу Зэвсэгт хүчний “Цэрэгжлийн спортын цол, зэргийн зөвлөл” олгоно.

4.3. Цэрэгжлийн спортын шүүгчийн зэргийг Зэвсэгт хүчний болон улсын чанартай тэмцээнийг шүүсэн туршлага, шүүгчийн мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал, шалгалтын дүн, зөвлөлийн шийдвэрийг үндэслэн олгоно.

4.4. Цэрэгжлийн спортын цол, зэргийн болзол биелүүлсэн тамирчин, шүүгч доорх материалыг бүрдүүлнэ.

4.4.1. Анги, байгууллагын албан бичиг;

4.4.2. Ажил байдлын тодорхойлолт /2 хуудаснаас ихгүй байна./

4.4.3. Цээж зураг 2 хувь

4.4.4. Монгол Улсын Спортын цол, зэргийн нэгдсэн ангиллын болзол биелүүлсэн тамирчин, шүүгчдийг тодорхойлох анкет;

4.4.5. Тухайн болзлыг хангасан тэмцээнд оролцож буй зураг /дүрс, бичлэг/;

4.4.6. Өргөмжлөл, дипломыг нотариатоор батлуулсан хуулбар.

4.5. Цэрэгжлийн спортын цол, зэргийн нэгдсэн ангиллын болзолыг биелүүлсэн тамирчин, шүүгчийн хүсэлт, холбогдох материалыг анги байгууллагын “Биеийн тамир, спортын зөвлөл”-ийн дарга хариуцан баталгаажуулж Зэвсэгт хүчний “Цэрэгжлийн спортын цол, зэргийн зөвлөл”-д ирүүлнэ.

4.6. “Цэрэгжлийн спортын цол, зэргийн зөвлөл”-д ирүүлсэн цолонд нэр дэвшигчийн хүсэлтийг 5 хоногийн дотор хянан үзэж, шаардлага хангасан материалыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.7. Цэрэгжлийн спортын зэргийн болзол биелүүлж, холбогдох материалыг ирүүлсэн тамирчин, шүүгчдийн хүсэлтийг 3 хоногийн дотор хянан, шийдвэрлэнэ.

4.8. Баримт бичгийн бүрдэл дутуу, гар бичмэл болон буруу хийгдсэн, зураггүй материалыг хүлээн авахгүй тухайн ирүүлсэн газарт буцаана.

4.9. Цэрэгжлийн спортын зэргийн тэмдэг, үнэмлэхийг нөхөн олгохдоо нөхөн олгохыг хүссэн өргөдөл, бүртгэл, тухайн оролцсон тэмцээний протокол, өргөмжлөлийг үндэслэн олгоно.

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН СУРГАЛТЫН ХЭЛТЭС**

ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ТӨРӨЛ, ЦОЛ, ЗЭРГИЙН НЭГДСЭН АНГИЛАЛ

Нийтлэг үндэслэл:

1. Зэвсэгт хүчний “Цэрэгжлийн спортын цол, зэргийн нэгдсэн ангилал” нь Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний биеийн тамир, спортын амжилт, ур чадварын түвшинг үнэлэх үндсэн баримт бичиг мөн.

2. Зэвсэгт хүчний спортын цол, зэрэг олгох нэгдсэн ангилал, тамирчин шүүгчдийн үзүүлсэн амжилтыг үндэслэн спортын мастер /СМ/, спортын дэд мастер /СДМ/ цолыг Монгол Улсын спортын цол олгох зөвлөл, I, II, III зэргийг Зэвсэгт хүчний цэрэгжлийн спортын цол зэргийн зөвлөл олгоно.

3. Цэрэгжлийн спортын төрөл, цол, зэргийн нэгдсэн ангиллын зэргийн нормативыг биелүүлсэн тохиолдолд давтан биелүүлэх заалтгүйгээр олгоно.

4. Цэрэгжлийн спортын цол, зэрэг олгох нэгдсэн ангилалд заагдаагүй төрөл бусад шалтгаанаар спортын цол, зэрэг олгохгүй.

5. Шүүгчийн цол, зэргийг улс, олон улсын чанартай тэмцээнийг шүүсэн туршлага, шүүгчийн мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал, зөвлөлийн шалгалтын дүн, шийдвэрийг үндэслэн холбогдох журмын дагуу олгоно.

Нэг: МАРШ ТАКТИК-ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН ЦОЛНЫ АНГИЛАЛ:

1.1. Зэвсэгт хүчний аварга шалгаруулах тэмцээн, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хооронд зохиогдсон цэрэгжлийн спортын тэмцээнд шалгарвал.

1.2. Цэрэгжлийн спортын цол:

Төрөл	СМ	СДМ
Марш тактикийн тэмцээн Эр 10 км, Эм 6 км	3 удаа I байр 1 удаа II байр	1 удаа I байр 2 удаа II байр
	2 удаа I байр 3 удаа II байр	2 удаа II байр 3 удаа III байр

1.3. Цэрэгжлийн спортын зэрэг:

Төрөл	I зэрэг	II зэрэг	III зэрэг
Марш тактикийн тэмцээн Эр 10 км, Эм 6 км	1 удаа I байр, 1 удаа II байр	1 удаа II байр, 2 удаа III байр:	3 удаа III байр:
	1 удаа I байр 2 удаа III байр	2 удаа II байр 1 удаа III байр	6 жил дараалан эхний 5 байранд шалгарсан

## Хоёр: ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН АВАРГЫН ЦОЛНЫ АНГИЛАЛ

2.1. Зэвсэгт хүчний аварга шалгаруулах тэмцээн, Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын хооронд зохиогдсон цэрэгжлийн спортын тэмцээнд шалгарвал.

### 2.2. Цэрэгжлийн спортын цол:

Төрөл	СМ	СДМ
Цэргийн мэргэжлийн аварга Эр 10 км	3 удаа I байр 1 удаа II байр	1 удаа I байр 2 удаа II байр
	2 удаа I байр 3 удаа II байр	2 удаа II байр 3 удаа III байр

### 2.3. Цэрэгжлийн спортын зэрэг:

Төрөл	I зэрэг	II зэрэг	III зэрэг
Цэргийн мэргэжлийн аварга Эр 10 км	1 удаа I байр, 1 удаа II байр	1 удаа II байр, 2 удаа III байр:	3 удаа III байр:
	1 удаа I байр 2 удаа III байр	2 удаа II байр 1 удаа III байр	6 жил дараалан эхний 5 байранд шалгарсан

## Гурав: ЦЭРГИЙН ГАРДАН ТУЛААНЫ ЦОЛНЫ АНГИЛАЛ

### 3.1. Цэрэгжлийн спортын цол:

Төрөл	СМ	СДМ
Зэвсэгт хүчний аварга шалгаруулах цэргийн гардан тулаан болон цэргийн гардан тулааны ОУ-ын тэмцээнд	3 удаа I байр 1 удаа II байр	1 удаа I байр 2 удаа II байр
	2 удаа I байр 3 удаа II байр	2 удаа II байр 3 удаа III байр

### 3.2. Цэрэгжлийн спортын зэрэг:

Төрөл	I зэрэг	II зэрэг	III зэрэг
Зэвсэгт хүчний аварга шалгаруулах цэргийн гардан тулаан болон цэргийн гардан тулааны ОУ-ын тэмцээнд	1 удаа I байр, 1 удаа II байр, 1 удаа III байр	2 удаа II байр, 1 удаа III байр	1 удаа II байр, 2 удаа III байр

## Дөрөв: ЦЭРГИЙН 3 ТӨРӨЛТИЙН ЦОЛНЫ АНГИЛАЛ

№	Ангилал	Буудлага		Гранат	3 км-ийн гүйлт		Нийт оноо
		амжилт	оноо		амжилт	оноо	
4.1	СМ	15	100	110	10,30	75	285
4.2	СДМ	14	94	101	10,51	68	263
4.3	I зэрэг	12	82	98	11,00	66	246
4.4	II зэрэг	11	76	94	11,15	61	231
4.5	III зэрэг	10	70	90	11,30	56	216

**Тав: ЦЭРЭГ, СПОРТЫН ЦОГЦОЛБОР НОРМЫН ЗУНЫ 5 ТӨРӨЛТИЙН ЦОЛНЫ АНГИЛАЛ**

Хүйс	Ангилал	СМ		СДМ		I зэрэг		II зэрэг		III зэрэг	
	Заалт	5.1		5.2		5.3		5.4		5.5	
	Насны ангилал	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо
Эр	18-30, 31-35	55	275	45	225	40	200	35	175	30	150
	36-40, 41дээш	54	270	44	220	40	200	35	175	30	150
Эм	18-30, 31-35	53	365	42	210	40	200	35	175	30	150
	36-40, 41дээш	50	250	39	195	38	190	33	165	29	145

**Зургаа: ЦЭРЭГ, СПОРТЫН ЦОГЦОЛБОР НОРМЫН ӨВЛИЙН 3 ТӨРӨЛТИЙН ЦОЛНЫ АНГИЛАЛ**

Хүйс	СМ		СДМ		I зэрэг		II зэрэг		III зэрэг	
	6.1		6.2		6.3		6.4		6.5	
	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо	Төрөл тус бүрд авах оноо	Нийлбэр оноо
Эр	58	174	55	165	50	150	45	135	40	120
Эм	55	165	52	156	48	144	44	132	40	120

**Долоо: ЦЭРЭГЖЛИЙН ГИМНАСТИКИЙН ЦОЛНЫ АНГИЛАЛ**

Заалт	Төрөл	Үнэлэх нэгж	СМ	СДМ	I зэрэг	II зэрэг	III зэрэг
7.1	Сонс эргэлт	тоо	400	350	300	250	200
7.2	Модон Моринд малгай тавьж харайх	Метр	12 малгай 2м 64 см	11 малгай 2м 52 см	10 малгай 2м 40 см	9 малгай 2м 28 см	8 малгай 2м 16 см
7.3	Олон төрөлт	балл	-	-	36,00	34,00	32,00

Найм: ЦЭРЭГЖЛИЙН БУУДЛАГЫН ЦОЛНЫ АНГИЛАЛ

Заалт	Төрөл	СМ	СДМ	I зэрэг	II зэрэг	III зэрэг
8.1	Гар буу ПМ 3+10 тогтоол	98 оноо	94 оноо	90 оноо	86 оноо	82 оноо
8.2	Автомат АК, АКМ 3x10	280 оноо	274 оноо	268 оноо	262 оноо	256 оноо
8.3	Гар буу ПМ хурдан буудлага	142 оноо	138 оноо	136 оноо	134 оноо	132 оноо
8.4	СВД	-	-	98	94	90

Ес: ТУУХАЙ ӨРГӨЛТИЙН ЦОЛНЫ АНГИЛАЛ

Заалт	Жингийн ангилал	Огцом өргөлт	Түлхэлттэй өргөлт	Нийлбэр оноо	Торгуулийн өргөлтийн оноо
Спортын мастер					
9.1	60 кг	96	27x2=54	150	2x5=10
	70 кг	108	32x2=64	172	2x5=10
	80 кг	122	35x2=70	192	2x5=10
	+80 кг	134	44x2=88	222	2x5=10
Спортын дэд мастер					
9.2	60 кг	82	23x2=46	128	2x4=8
	70 кг	96	27x2=54	150	2x4=8
	80 кг	108	32x2=64	172	2x4=8
	+80 кг	122	35x2=70	192	2x4=8
I зэрэг					
9.3	60 кг	70	19x2=38	108	2x3=6
	70 кг	84	23x2=46	130	2x3=6
	80 кг	96	28x2=56	152	2x3=6
	+80 кг	110	31x2=62	172	2x3=6
II зэрэг					
9.4	60 кг	62	17x2=34	96	2x2=4
	70 кг	76	21x2=42	118	2x2=4
	80 кг	88	26x2=52	140	2x2=4
	+80 кг	102	29x2=58	160	2x2=4
III зэрэг					
9.5	60 кг	54	15x2=30	84	2x2=4
	70 кг	68	19x2=38	106	2x2=4
	80 кг	80	24x2=48	128	2x2=4
	+80 кг	94	27x2=54	148	2x2=4

Арав: ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ӨВЛИЙН 2 ТӨРӨЛТИЙН ЦОЛНЫ АНГИЛАЛ

Заалт	Зай, төрөл	СМ	СДМ	I зэрэг	II зэрэг	III зэрэг
10.1	Биатлон 15 км	0:57:00	1:00:00	1:03:00	1:06:00	1:10:00
10.2	Патруль 10 км	0:50:00	0:52:00	0:54:00	0:56:00	0:58:00

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН СУРГАЛТЫН ХЭЛТЭС